



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 09 сарын 13 өдөр

Дугаар 420

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа,
үнийг шинэчлэн тогтоож, балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 5.6, 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Хөгжлийн хөтөч-дэд бүтэц" төслийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 10,260,000.00 (арван сая хоёр зуун жаран мянга) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий Хьюндай Азера маркийн, 39-62 УНӨ улсын дугаар, КМНФН41ВВСА156692 арлын дугаартай тээврийн хэрэгслийн ашиглах хугацааг 2 жилээр сунгаж, нийт үнийг 5,000,000.00 (таван сая) төгрөгөөр шинэчлэн тогтоож "Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. "Хөгжлийн хөтөч-дэд бүтэц" төслийн зохицуулагч Ж.Ганбаатар, "Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Н.Мөнгөнхөлөгт нарт дор дурдсан арга хэмжээг авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгийн ашиглах хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3. Тээврийн хэрэгслийг татвар төлөгчийн бүртгэл, улсын бүртгэлээс шилжүүлж арга хэмжээний биелэлтийг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх;

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132001990
20-r huraldaan.docx